



ДУНДГОВЬ АЙМАГ
ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 16 өдөр

Дугаар

А/15

Хараат

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлмйн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.12, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, 15 дугаар зүйлийн 15.1 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2023 оны сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Байгаль хамгаалах сангаас 2023 онд хийгдэх төлөвлөгөөний дагуу амьтны тооллого хийлгэх, шувууны суудал хийлгэх ажлыг 2023 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 06 дугаар сарын 30-ний хооронд зохион байгуулсугай.
2. Амьтны тооллого хийлгэх, шувууны суудал хийлгэхэд шаардлагатай хөрөнгийг хавсралтаар баталсугай.
3. Дээрхи ажилд шаардлагатай 12,000.000 (Арван хоёр сая) төгрөгийг байгаль хамгаалах сангаас гаргахыг нягтлан бодогч (Ж.Чулуунтогтох)-д зөвшөөрсүгэй.
4. Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, байгаль хамгаалах сангийн үйл ажиллагаа, төлөвлөгөөний дагуу тухайн зардлыг тооцон олгохыг Тамгын газрын дарга (Ш.Мөнх-Оргил)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  А.ЭРДЭНЭСАЙХАН



4823000078

Дундговь аймгийн Цагаандэлгэр Сумын
Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын
06 ны өдрийн 15 дугаар захирамжийн
хавсралт



АЖЛЫН ЗАРДЛЫН ТООЦОО

Д/Д	НЭР	МӨНГӨН ДҮН	ДҮН
1	Амьтны тооллого хийлгэх	6000000	6000000
2	Шувууны суудал хийлгэх	6000000	6000000
	НИЙТ	-	12000000